



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/105/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор
2023 оны 02 дугаар сарын 10

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цээням
Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn
Аудитор: Н.Батчимэг
Утас: 91113253 Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.3 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2023.02.14 № 2/12
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн дарга "Сити сейф" ХХК-тай 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр 19.9 сая төгрөгийн үнэ бүхий архивын нягтруулсан шүүгээг 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн дотор нийлүүлэхээр "Худалдах, худалдан авах гэрээ" байгуулж гэрээ байгуулсантай холбоотойгоор тайлант оны эцэст авлага данс үлдэгдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилго, 8 зорилтын хүрээнд 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газраас 90.3 хувиар үнэлсэн байна.

005020136

Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

A handwritten signature in black ink is written over a red official stamp. The stamp contains Mongolian text and a circular emblem, likely representing the State Audit Agency. The signature is written in a cursive style.

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	44,710,794.00	58,399,170.50
33	АВЛАГА	00.00	19,905,600.00
335	Бусад авлага	00.00	19,905,600.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	19,905,600.00
35	БАРАА МАТЕРИАЛ	44,710,794.00	38,493,570.50
351	Түүхий эд материал	18,345,764.00	17,544,715.50
35110	Тусгай зориулалттай материал	18,345,764.00	17,544,715.50
35300	Бэлэн бүтээгдэхүүн	732,300.00	5,882,875.00
354	Хангамжийн материал	25,632,730.00	15,065,980.00
35410	Бичиг хэргийн материал	757,750.00	728,000.00
35420	Аж ахуйн материал	12,448,700.00	6,911,700.00
35430	Сэлбэг хэрэгсэл	49,500.00	49,500.00
35470	Бусад хангамжийн материал	12,376,780.00	7,376,780.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,114,995,307.55	1,075,836,797.37
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,114,995,307.55	1,075,836,797.37
392	Биет хөрөнгө	1,100,695,307.55	1,061,536,797.37
39201	Барилга, байгууламж, орон сууц	919,078,168.00	919,078,168.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-46,890,258.48	-62,520,344.64
39203	Авто-тээврийн хэрэгсэл	28,000,000.00	28,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-28,000,000.00	-28,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	299,254,437.17	339,187,109.17
39206	Хуримтлагдсан элэгдэл	-95,786,785.78	-154,664,831.96
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	81,014,800.00	81,644,800.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-57,532,946.76	-62,745,996.60
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,557,893.40	1,557,893.40
393	Биет бус хөрөнгө	14,300,000.00	14,300,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	14,900,000.00	14,900,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-600,000.00	-600,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,159,706,101.55	1,134,235,967.87
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,159,706,101.55	1,134,235,967.87
51	Засгийн газрын хувь оролцоо	1,159,706,101.55	1,134,235,967.87
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	14,300,000.00	14,300,000.00
51101	Өмч: - төрийн	14,300,000.00	14,300,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	854,455,735.63	828,985,601.95
51210	Өмнөх үеийн үр дүн	854,455,735.63	854,455,735.63
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-25,470,133.68
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	290,950,365.92	290,950,365.92
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,159,706,101.55	1,134,235,967.87

Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Узүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	967,321,780.92	677,141,623.69
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	273,818,080.92	47,375,823.69
120	Нийтлэг татварын бус орлого	273,818,080.92	47,375,823.69
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	273,818,080.92	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	273,818,080.92	00.00
120009	Бусад орлого	00.00	88,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	693,503,700.00	629,765,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	602,284,800.00	610,283,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	602,284,800.00	610,283,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	91,218,900.00	19,482,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	15,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	91,218,900.00	3,982,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	775,744,699.96	691,111,757.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	775,744,699.96	691,111,757.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	771,399,453.96	677,031,212.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	459,200,445.21	439,202,689.00
210101	Үндсэн цалин	384,293,245.21	348,320,643.00
210102	Нэмэгдэл	57,403,200.00	80,322,046.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,504,000.00	10,560,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,463,612.79	61,349,271.00
210201	Тэтгэврийн даатгал	52,920,555.79	43,495,571.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,197,572.00	4,463,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,358,057.00	3,570,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	816,957.00	892,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,170,471.00	8,926,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,794,399.00	50,085,471.00
210301	Гэрэл, цахилгаан	2,352,483.00	2,570,856.00
210302	Түлш, халаалт	44,083,300.00	45,328,799.00
210303	Цэвэр, бохир ус	1,358,616.00	2,185,816.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,784,405.80	18,917,340.00
210401	Бичиг хэрэг	9,495,530.00	9,504,350.00
210402	Тээвэр, шатахуун	5,081,000.00	4,414,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,633,853.00	1,928,090.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,999,800.00	2,470,000.00
210408	Бараа материал акталсны зардал	1,974,222.80	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,279,810.00	2,629,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	568,000.00	00.00

Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	32,411,810.00	270,000.00
210604	Урсгал засвар	300,000.00	2,359,600.00
2107	Томилолт, зочны зардал	211,200.00	00.00
210702	Дотоод албан томилолт	211,200.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,431,637.95	12,136,807.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	694,064.00	2,457,034.00
210803	Даатгалын үйлчилгээ	330,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	100,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	00.00
210807	Газрын төлбөр	57,200.00	176,200.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	10,208,373.95	9,402,773.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	127,233,943.21	92,710,033.87
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	488,000.00	550,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	35,528,903.21	72,677,433.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,345,246.00	14,080,545.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	345,000.00	100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	345,000.00	100,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,000,246.00	13,980,545.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,998,386.00	13,892,545.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	191,577,080.96	-13,970,133.68
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,722,500.00	11,500,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,722,500.00	-11,500,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	189,854,580.96	-25,470,133.68

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	940,693,081.33	829,157,040.07
11	ТАТВАРЫН ОРЛОГО	16,893,305.70	00.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	16,893,305.70	00.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	16,893,305.70	00.00
118001	Улсын тэмдэгтийн хураамж	16,893,305.70	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	230,296,075.63	199,391,240.07
120	Нийтлэг татварын бус орлого	230,296,075.63	199,391,240.07
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	230,296,075.63	199,391,240.07
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	230,296,075.63	199,303,240.07
120009	Бусад орлого	00.00	88,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	693,503,700.00	629,765,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	602,284,800.00	610,283,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	602,284,800.00	610,283,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	91,218,900.00	19,482,600.00

Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	15,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	91,218,900.00	3,982,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	943,811,984.83	829,157,040.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	943,811,984.83	829,157,040.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	689,158,454.00	615,773,255.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	456,458,700.00	439,202,689.00
210101	Үндсэн цалин	377,714,500.00	348,320,643.00
210102	Нэмэгдэл	61,240,200.00	80,322,046.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,504,000.00	10,560,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,205,358.00	61,349,271.00
210201	Тэтгэврийн даатгал	56,741,058.00	43,495,571.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,619,000.00	4,463,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,158,700.00	3,570,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	789,700.00	892,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,896,900.00	8,926,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,794,399.00	50,085,471.00
210301	Гэрэл, цахилгаан	2,352,483.00	2,570,856.00
210302	Түлш, халаалт	44,083,300.00	45,328,799.00
210303	Цэвэр, бохир ус	1,358,616.00	2,185,816.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,927,683.00	18,870,990.00
210401	Бичиг хэрэг	7,318,330.00	9,458,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,081,000.00	4,414,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,633,853.00	1,928,090.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	309,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,294,500.00	2,760,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,632,810.00	23,498,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	833,000.00	20,868,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	499,810.00	270,000.00
210604	Урсгал засвар	300,000.00	2,359,600.00
2107	Томилолт, зочны зардал	211,200.00	00.00
210702	Дотоод албан томилолт	211,200.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,223,264.00	2,734,034.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	694,064.00	2,457,034.00
210803	Даатгалын үйлчилгээ	330,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	100,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	00.00
210807	Газрын төлбөр	57,200.00	176,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	91,705,040.00	20,032,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	488,000.00	550,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	254,653,530.83	213,383,785.07

Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
2132	Бусад урсгал шилжүүлэг	345,000.00	100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	345,000.00	100,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	234,296,321.63	213,283,785.07
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,998,386.00	13,892,545.00
213306	Төвлөрүүлэх шилжүүлэг	230,296,075.63	199,303,240.07
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,860.00	88,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	16,893,305.70	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,893,305.70	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,300,000.00	290,950,365.92	664,601,154.67	00.00	969,851,520.59
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,300,000.00	290,950,365.92	664,601,154.67	00.00	969,851,520.59
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	189,854,580.96	00.00	189,854,580.96
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,300,000.00	290,950,365.92	854,455,735.63	00.00	1,159,706,101.55
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,300,000.00	290,950,365.92	854,455,735.63	00.00	1,159,706,101.55
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,300,000.00	290,950,365.92	854,455,735.63	00.00	1,159,706,101.55
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-25,470,133.68	00.00	-25,470,133.68
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,300,000.00	290,950,365.92	828,985,601.95	00.00	1,134,235,967.87

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	610,283,200.00	596,390,655.00	13,892,545.00	97.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	610,283,200.00	596,390,655.00	13,892,545.00	97.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	610,039,200.00	596,290,655.00	13,748,545.00	97.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	446,343,300.00	439,202,689.00	7,140,611.00	98.4

Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан					
210101	Үндсэн цалин	373,528,500.00	348,320,643.00	25,207,857.00	93.3
210102	Нэмэгдэл	62,254,800.00	80,322,046.00	-	129.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,560,000.00	10,560,000.00	0.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,292,900.00	61,349,271.00	4,943,629.00	92.5
210201	Тэтгэврийн даатгал	48,439,200.00	43,495,571.00	4,943,629.00	89.8
210202	Тэтгэмжийн даатгал	4,463,400.00	4,463,400.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,570,700.00	3,570,700.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	892,700.00	892,700.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	8,926,900.00	8,926,900.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,263,700.00	50,085,471.00	178,229.00	99.6
210301	Гэрэл, цахилгаан	2,707,600.00	2,570,856.00	136,744.00	94.9
210302	Түлш, халаалт	45,911,000.00	45,328,799.00	582,201.00	98.7
210303	Цэвэр, бохир ус	1,645,100.00	2,185,816.00	-540,716.00	132.9
2104	Хангамж, бараа материалын зардал	18,871,400.00	18,870,990.00	410.00	100.0
210401	Бичиг хэрэг	9,173,500.00	9,458,000.00	-284,500.00	103.1
210402	Тээвэр, шатахуун	4,414,900.00	4,414,900.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,664,200.00	1,928,090.00	-263,890.00	115.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	309,300.00	309,300.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,309,500.00	2,760,700.00	548,800.00	83.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,577,700.00	23,498,200.00	1,079,500.00	95.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	21,944,600.00	20,868,600.00	1,076,000.00	95.1
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	273,500.00	270,000.00	3,500.00	98.7
210604	Урсгал засвар	2,359,600.00	2,359,600.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,843,300.00	2,734,034.00	109,266.00	96.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,566,300.00	2,457,034.00	109,266.00	95.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,800.00	100,800.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	176,200.00	176,200.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	846,900.00	550,000.00	296,900.00	64.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	846,900.00	550,000.00	296,900.00	64.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	244,000.00	100,000.00	144,000.00	41.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	244,000.00	100,000.00	144,000.00	41.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	244,000.00	100,000.00	144,000.00	41.0

Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	610,283,200.00	610,283,200.00	0.00	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	610,283,200.00	610,283,200.00	0.00	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	610,283,200.00	610,283,200.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Узүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	19,570,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	19,570,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	19,482,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19482600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,482,600.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	88,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	19482600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,482,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,982,600.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь улсын бүртгэлийн ерөнхий хууль, улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг, “Иргэнийхээ язгуур эрх ашгийг эрхэмлэх дээдэлж, бүртгэлийн үйлчилгээг шуурхай хүргэх” гэсэн эрхэм зорилготой Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяа байгууллага юм.

Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь бүртгэл хяналт, иргэний бүртгэл, эд хөрөнгийн эрхийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэл чиглэлээр 40 албан хаагчтайгаар бүртгэлийн үйлчилгээг хуулийн хүрээнд үзүүлдэг.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг дарга Ц.Мөнхжаргал, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Г.Бат-Очир нар зурж, няраваар Р.Доржнямбуу ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж эхэлсэн.
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор цалингийн шатлал өөрчлөгдсөн.
- Засгийн газрын 2022 оны 120 дугаар тогтоолоор албан томилолтын зардлын тариф өөрчлөгдсөн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

УБЕГ-ын Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газар нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузул сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Оюуны өмч, УБЕГ-ын даргын 2017 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн “Бодлогын баримт бичиг батлах тухай” А/904 тоот тушаалаар баталсан НББББ-ийг мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1,134,236.0 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 25.47061 мянган төгрөгөөр буюу 2.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	19,905.6	19,905.6
Бараа материал	44,710.8	38,493.6	(6,217.2)
Үндсэн хөрөнгө	1,343.805.3	1,384,367.9	40,562.6
Хуримтлагдсан элэгдэл	(228,810.0)	(308,531.2)	(79,721.2)

Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
Нийт хөрөнгө	1,159,706.1	1,134,236.0	(25,470.1)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,159,706.1	1,134,236	25,470.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,159,706.1	1,134,236.0	25,470.1

Дээрх хүснэгтээс харахад, авлага данс тайлант оны эцэст 19,905.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн дарга “Сити сейф” ХХК-тай 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр 19,905.5 мянган төгрөгийн (нэг бүр нь 1,244,100 төгрөгийн үнэтэй 16 ширхэг) үнэ бүхий архивын нягтруулсан шүүгээг 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн дотор нийлүүлэхээр “Худалдах, худалдан авах гэрээ” байгуулж гэрээ байгуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 38,493.6 мянган төгрөг болж өмнөх оноос 6,217.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 23,659.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, УБЕГ-аас 13,768.9 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авч, үйл ажиллагаандаа 32,146.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022.01.25-ны өдрийн А-1/163 тоот албан бичгээр бараа материалын дансанд бүртгэлтэй 6,500.0 мянган төгрөгийн, 2022.01.08-ны өдрийн “Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай” 08 тоот тогтоолоор 5,000.0 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн бүртгэсэн 11,500.0 мянган төгрөгийн бараа материалын дансанд бүртгэлтэй хөрөнгийг үндсэн хөрөнгөд шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,384,367.9 мянган төгрөг болж 39,158.5 мянган төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022.05.13-ны өдрийн 202 дугаар тогтоолоор 23,870.0 мянган төгрөгийн хөрөнгө, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022.10.04-ний өдрийн 202 дугаар тогтоолоор 23,870.0 мянган төгрөгийн хөрөнгө балансаас балансад шилжүүлэн авсан боловч хуримтлагдсан элэгдлийн зардал 79,721.2 төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Тайлант онд өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,134,236.0 мянган төгрөг болж 25,470.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 25,470.1 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх

үүсвэрийг улсын төсвөөс 643.123.5 мянга, үйл ажиллагааны орлогоос 200,000.0 мянга, нийт зарлагыг 643.123.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин, хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 49,106.4 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 37,627.8 мянган төгрөгөөр бууруулж, 556,389.3 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотойгоор өмнөх оны төсвийг бууруулан баталсантай холбоотой байна. 2022 оны 11 дүгээр сард батлагдсан төсвийг 521,583.2 мянган төгрөг болгож 65,193.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 621,583.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж, үйл ажиллагааны орлогоос 200,000.0 мянган төгрөгийг улсын төсөвт бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 610,283.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 199,303.2 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 596.390.6 мянган төгрөг буюу 97.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 13,892.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70701 Улсын бүртгэл, мэдээлэл	610,283.2	596,390.6	13,892.5	97.7
2	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	610,039.2	596,290.7	13,748.5	97.7
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	244.0	100.0	144.0	40.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Засаг даргын 2022.01.18-ны өдрийн А/30 тоот захирамжаар АЗДТГ-ын ангилагдаагүй зардлаас иргэдийн хаягийн шинэчлэлийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд шинэчлэх ажилд 15,500.0 мянган төгрөг санхүүжилт олгосноос 13,644.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1,855.1 мянган төгрөгийг буцаан ангилагдаагүй зардлын дансанд төвлөрүүлсэн байна.

Мөн нөхөн сонгуулийн зардалд 3,982.6 мянган төгрөг 2022 оны 05 дугаар сард олгосныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цээням, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 1/17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 691,111.7 мянган төгрөгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 691,111.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,366.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 7,256.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь тайлант онд 5 орон тоо (тэтгэвэрт-2, өөрийн хүсэлтээр-2, ажил олгогчийн санаачлагаар-1) ажилласнаар цалин, хөлс нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардал 12,084.2 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна. Тайлант онд нийт 13,892.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2022 онд 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 149 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнд 15,500.0 мянган төгрөгийн 1 гүйлгээг дутуу мэдээлсэн байна.

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээнд цалин, НДШ, ХХОАТ, 5 сая төгрөгөөс доош үнийн дүн зарлагын гүйлгээг мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн, мэдээллийг хугацаанд нь цахим хуудаст үнэн зөв дүнгээр байршуулж буйд тавих төсвийн шууд захирагчийн хяналтыг сайжруулах.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 293.9 мянган төгрөгийн төлбөрийн актыг бүрэн барагдуулж, нийгмийн даатгалд зөрүүтэй мэдээлсэн 1,338.4 мянган төгрөгийн албан шаардлагыг биелүүлж нөхөн мэдээлж, Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2022.03.25-ны өдрийн 1/22 дугаар албан бичгээр биелэлтийг ирүүлснийг FAS системд хэрэгжилтийг оруулж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	293.9	1	293.9	100

Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Албан шаардлага	1	1,338.4	1	1,338.4	100
Нийт дүн	2	1,578.3	2	1,578.3	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 19,905.6 мянган төгрөгийн алдаа¹ илэрч дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Илрүүлэлт: Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн дарга нь “Сити сейф” ХХК-тай 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр 19,905.6 мянган төгрөгийн үнэ бүхий архивын нягтруулсан шүүгээг 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн дотор нийлүүлэхээр “Худалдах, худалдан авах гэрээ” байгуулж 2022.12.13-ны өдөр багаж техник хэрэгслийн зардлаас 19,905.6 мянган төгрөгийг шилжүүлсэн бөгөөд тайлант оны эцэст авлагатай гарсан байна. УБЕГ-аас байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зайлшгүй шаардлагатай байсан тул багаж техник хэрэгслийн зардалд дээрх хөрөнгийг 2022 оны 11 дүгээр сард суулгаж өгсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгийг гэрээнд заасан хугацаанд бүрэн хүлээн авч, цаашид төсвийн шууд захирагч нь төсвийг үр ашигтай удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,